

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1080

танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Гэр хороолол хөгжлийн нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Гэр хороолол хөгжлийн нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


“Гэр хороолол хөгжлийн нам”-ын мөрийн хөтөлбөр /.....7 хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030705



“ГЭР ХОРООЛОЛ ХЭГЖЛИЙН НАМ”

**“ОЛИГАРХИГҮЙ МОНГОЛ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Улаанбаатар хот

2024 он

Оршил

“Гэр Хороолол Хөгжлийн Нам” нь 2019 оноос улс төрийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд алхам алхамаар хүрээгээ тэлж, улам бүр олны дэмжлэгийг олж байна.

Гэр Хороолол Хөгжлийн Нам нь улс төрийн томоохон намуудаас ялгаатай нь хүн амын олонхи болж байгаа гэр хорооллынхны эрх ашгийг хамгаалах, ахуй соёлыг өвөрмөцөөр хөгжүүлэхэд чиглэгдэж байгаагаараа онцлог юм. Гэр хороолол гэдэг нь амьдарч буй ахуй, соёл, сэтгэлгээ, тэмүүллээрээ улам бүр ялгаатай болж буй хүн амын хэсэг бөгөөд үүнд Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдыг ойлгож байна.

Монгол улсын хөгжлийн сүүлийн 30 жил тохиож байгаа нийгмийн томоохон үзэгдэл бол иргэд эрх чөлөөтэй болж, Үндсэн хуулиар өөрийн оршин сууж амьдрах газрыг сонгох эрхтэй болсон билээ.

Энэхүү өөрчлөлттэй холбоотойгоор хөдөө нутгаас баг руу, багаас сум руу, сумаас аймгийн төв рүү, аймгийн төвөөс хот газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн болсон байдаг.

Энэ нь хүн бүр, өрх бүр

- Амьдралаа дээшлүүлэх
- Чанартай боловсрол үр хүүхэддээ олгох
- Найдвартай эрүүл мэндийн үйлчилгээ авах
- Жижиг үйлдвэрлэл эрхэлж том зах зээлд бүтээгдэхүүний борлуулах
- Ирээдүйгээ итгэлтэй бүтээх

хүний эрмэлзэлтэй холбоотой бодит үзэгдэл юм.

Гэр хорооллынхон бол дэлхийд монгол соёл иргэншлийг хамгаалан түгээх сүүлчийн голомт юм.

Гэр хорооллынхон бол жижиг дунд үйлдвэрлэлийг эрхлэх сонирхол бүхий нийгмийн давхарга юм.

Гэр хорооллынхон бол төрийн бодлогын анхааралд өртөөгүй хүн амын давхарга юм.

Гэр хорооллынхон бол хэнээс ч тусламж дэмжлэг хүсч байгаагүй шударгаар амьдрагчид юм.

Энэ утгаараа гэр хорооллынхон бол бие даасан эрх ашиг бүхий хүн амын давхарга гэдэгт Гэр Хороолол Хөгжлийн Нам итгэлтэй байна.

Гэр Хороолол Хөгжлийн Нам нь Монголын нийгэм дэх Тэгш бус байдлыг арилгахыг улс төрийн зорилгоо болгож байгаа. Үүнд хүн амын орлогын тэгш бус байдал, Боловсрол олж авах тэгш бус байдал, Эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх тэгш бус байдал, Санхүү зээлийн эх үүсвэрт хүрэх тэгш бус байдал, Эмэгтэйчүүдийг ялгаварласан тэгш бус байдлыг арилгах асуудлууд хамаарна. Эдгээр зорилт нь алхам алхмаар хэрэгжих нь ойлгомжтой.

Дээрх зорилтуудад хүрэхийн тулд УИХ-ын ээлжит сонгуульд Гэр Хороолол Хөгжлийн НАМ өөрийн төлөөлөлтэй болох явдал юм. Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд гэр хорооллынхны эрх ашгийг мэдэрдэг, түүний төлөө ажиллаж чадах боловсон хүчнүүдийг дэвшүүлэх бөгөөд тэдний баримтлах 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн Мөрийн Хөтөлбөрийг “Олигархигүй Монгол” гэж томъёолов.


“ГЭР ХОРООЛОЛ ХӨГЖЛИЙН НАМ”-ЫН

“ОЛИГАРХИГҮЙ МОНГОЛ”

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА:

1. Эдийн засгийн реформ, бүтээн байгуулалтыг - ГЭР ХОРООЛОЛД
2. Авлигагүй төр - АРД ТҮМНИЙ ИТГЭЛ
3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал – ГЭР ХОРООЛОЛД
4. ОЛИГАРХИГҮЙ - МОНГОЛ



1. Эдийн засгийн реформ, бүтээн байгуулалтыг - ГЭР ХОРООЛОЛД

1.1 УИХ-аар баталсан Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг хангаж, “Алсын хараа-2050” хөтөлбөрт тусгагдсан Гэр хорооллын ард иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.

1.2 УИХ-аар баталсан Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг хангаж, хашааны газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор гэр хорооллыг дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой болгож хэрэгжүүлэх орчныг бүрдүүлнэ.

1.3 Гэр хорооллын хөгжлийг дэмжих бодлого баримталж, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.4 Монгол улсын хөгжлийн төлөвлөлтийн үндэс нь Гэр хорооллын хөгжилд тулгуурласан байх зарчмыг баримтлана.

2. Авлигагүй төр - АРД ТҮМНИЙ ИТГЭЛ

2.1 Эрх баригч, шийдвэр гаргагч төрийн албан хаагчдын дунд авлигаар хөлждөг, хөрөнгөждөг байдлыг таслан зогсоох бүхий л хуулийн орчныг бүрдүүлнэ.

2.2 Авлига, арын хаалгаар “худалддаг” дарга нарын гарын үсгийг иргэдийн өмнө ил “лангуун” дээр тавьж, төрийн албаны хүнд суртлыг арилгана.

2.3 Төрийн үйлчилгээний бүхий л шийдвэр, зөвшөөрөл, лицензийг ил тод нээлттэй байлгаж, ард иргэдэд түргэн шуурхай үйлчилж, АВЛИГАГҮЙ ТӨРИЙГ бий болгох орчин нөхцлийг бүрдүүлнэ.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллыг - ГЭР ХОРООЛОЛД

3.1 Гэр хорооллын хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн бүтэц бий болгох санаачлага гаргана.

3.2 Гэр хорооллын ажилгүйдлийг, ялангуяа залуус, эмэгтэйчүүдийн ажилгүйдлийг бууруулах бодлого баримтлана.


3.3 Засгийн газраас хэрэгжүүлж буй өрх толгойлсон эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлогыг эрчимжүүлнэ.

3.4 УИХ-аар баталсан Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, “Алсын хараа-2050” хөтөлбөрт тусгагдсан гэр хорооллын

газрыг шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх зэрэг бүтээн байгуулалтын хөтөлбөрүүдийг эрчимжүүлнэ.


4. ОЛИГАРХИГҮЙ - МОНГОЛ

4.1 Улсын хөгжлийг гацааж, ард түмний боломжийг хулгайлж, төрийг хүчгүйдүүлж буй хууль бусаар хөрөнгөжсөн олигархуудыг зогсоох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлого баримтална.



“ГЭР ХОРООЛОЛ ХӨГЖЛИЙН НАМ”

“ОЛИГАРХИГҮЙ МОНГОЛ”



2024 он

00000007

Бүтэцх.